

**МОНГОЛ ДААТГАЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр

№01

Улаанбаатар хот

“Монгол Даатгал” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Монгол Улсын Компанийн тухай хуулийн 60, 64, 65 дугаар зүйл болон 62 дугаар зүйлийн 62.1 дэх заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тоот тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын 2.2 дахь заалт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу 2025 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 12:00 цагаас Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Үндсэн хуулийн гудамж 32, “Монгол даатгал” ХК-ийн байрны 3 давхрын хурлын танхимд хуралдав.

Хурлын дарга Э.Алтанзул: “Монгол Даатгал” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож байгаа та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье!

2025 оны 3 дугаар сарын 21-ний өдөр Төлөөлөн удирдах зөвлөлийн эчнээ санал хураалтаар “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах тухай” 25/12 тоот тогтоолыг компанийн тухай хуульд нийцүүлэн гаргасан.

Хуралд ТУЗ-ийн нарийн бичгийн даргын ажлыг хавсран гүйцэтгэгч, тус хурлын комиссын дарга Х.Доржзовд, Тооллогын комиссын дарга Ц.Тогтохбаяр, гишүүн А.Болоржаргал, “Монгол даатгал” ХК-ийн Гүйцэтгэх захирал М.Од, Хурлын дарга Э.Алтанзул, Компанийн Ерөнхий эдийн засагч Т.Бат-Өлзий, хувьцаа эзэмшигч “Милленниум Секьюритис Менежмент Лимитед” ХХК-г төлөөлж Т.Цацрал, хувьцаа эзэмшигч Ж.Пүрэвсүрэн нар оролцож байна. Тооллогын комисс хувьцаа эзэмшигчдэд хурлын ирцийг танилцуулна уу.

Тооллогын комиссын дарга Ц.Тогтохбаяр: “Монгол Даатгал” ХК нь нийт 64,132,341 ширхэг хувьцаатай, саналын хайрцагнаас нийт 3 саналын хуудас гарлаа. Нийт 275 хувьцаа эзэмшигч байна. “Милленниум Секьюритис Менежмент Лимитед” ХХК компани 63,997,215 ширхэг хувьцаатай, Ж.Пүрэвсүрэн 87 ширхэг хувьцаатай байна. Нийт саналын эрхтэй 63,997,302 ширхэг хувьцаатай буюу 99,7 хувийн ирцтэй байна.

“Компанийн тухай хууль”-ийн 69.1 дэх заалтыг үндэслэн хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцох тухай Тооллогын комиссын анхдугаар тогтоолыг танилцуулья.

Тооллогын комиссын дарга Ц.Тогтохбаяр тооллогын комиссын 25/01 тоот тогтоолыг уншиж танилцуулав.

Хурлын дарга Э.Алтанзул: Хурлын ирц хүрсэн учраас хурлаа нээж, Монгол Даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 3 дугаар сарын 21-ны өдрийн тогтоолыг болон уг тогтоолоор баталсан хурлын дэгийг танилцуулья.

ТУЗ-ийн тогтоолыг бүтнээр нь уншиж танилцуулав.

Хурлын дарга Э.Алтанзул: Хурлаар хэлэлцэх асуудлуудын материалыг та бүхэнд урьдчилан хүргүүлсэн. Хурлын дэгийн дагуу эхний танилцуулах асуудал бол Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж, батлах тухай асуудлыг танилцуулна уу хэмээн Гүйцэтгэх захирал М.Одыг урьж байна.

Гүйцэтгэх захирал М.Од: Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулав.

Хурлын дарга Э.Алтанзул: Гүйцэтгэх захирал М.Од танд баярлалаа! Дараагийн танилцуулах асуудал бол Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд нэр дэвшигчдийг танилцуулахаар байна.

Хурлын дарга Э.Алтанзул тус асуудлыг танилцуулав.

Хурлын дарга Э.Алтанзул: Дараагийн танилцуулах асуудал бол 2025 оны ТУЗ-ийн зардлын төсвийн төслийг Гүйцэтгэх захирал М.Од танилцуулна.

Гүйцэтгэх захирал М.Од: Компанийн 2025 оны ТУЗ-ийн зардлын төсвийн төслийг танилцуулав.

Хурлын дарга Э.Алтанзул: Хурлын дэгийн дагуу та бүхэнд хэлэлцэж буй асуудлууд болон хурлын материалтай холбогдсон асуулт байна уу?

Хувьцаа эзэмшигч Ж.Пүрэвсүрэн: *Ногдол ашиг хэзээ тараах вэ?*

Гүйцэтгэх захирал М.Од: *Одоогоор компани ашигтай ашиггүй ажиллаж байгаа учраас ногдол ашиг тараах боломжгүй. Компани ашигтай ажиллаад ирэхээр ТУЗ-өөс шийдвэр гаргах байх аа гэв.*

Хуралд оролцогчдоос өөр асуулт гарсангүй.

Хурлын дарга Э.Алтанзул: Та бүхэнд хурлаас гарах шийдвэрийн төсөлтэй холбогдсон асуулт байна уу?

Хуралд оролцогчдоос асуулт гарсангүй.

Хурлын дарга Э.Алтанзул: Хуралд оролцогчдоос асуулт гараагүй учир хурлаа үргэлжлүүлэн тооллогын комиссын дарга Ц.Тогтохбаяр санал тоолох ажил дууссан бол саналын дүнг танилцуулна уу.

Тооллогын комиссын дарга Ц.Тогтохбаяр: Санал тоолох ажил дууслаа. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын дүн дараах байдалтай байна. Нийт 63,997,302 саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид саналаа өгч хэлэлцсэн бүх асуудлаар 100 хувийн саналаар зөвшөөрсөн байна. Татгалзсан санал байхгүй тул баталсанд тооцов.

Тооллогын комиссын дарга Ц.Тогтохбаяр тооллогын комиссын 25/02 тоот тогтоолыг уншиж танилцуулав.

Хурлын дарга Э.Алтанзул: Тооллогын комисс шийдвэрээ танилцууллаа. Үүнийг үндэслэж хурлаас гарах шийдвэрүүдийг танилцуулья.

Нэгдүгээр асуудлаар: Компанийн тухай хуулийн 62.1.9, 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын 25/02 тоот тогтоолыг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ НЬ:

“Монгол Даатгал” ХК-ийн 2024 оны компанийн санхүү, үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

Хоёрдугаар асуудлаар: Компанийн тухай хуулийн 62.1.13, 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын 25/02 тоот тогтоолыг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ НЬ:

ТУЗ-ийн 2025 оны төсвийг Хавсралт №01-ээр баталсугай. Батлагдсан төсвийг мөрдөн, ТУЗ-ийн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулан, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг удирдан чиглүүлж ажиллахыг ТУЗ /Громов С.Б./-д үүрэг болгосугай.

Гуравдугаар асуудлаар: Компанийн тухай хуулийн 62.1.7, 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын 25/02 тоот тогтоолыг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ НЬ:

“Монгол Даатгал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгож, Дараах 6 нэр дэвшигчийг ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгосугай:

1. Громов Сергей Борисович
2. Огай Наталья Юрьевна
3. Мөнхбаатарын Од
4. Лизуновагийн Таня
5. Энхсайханы Алтанзул
6. Баяртогтохын Энхбаяр

Дараах 3 нэр дэвшигчийг ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгосугай:


1. Сэдбазарын Отгонбат
2. Батмөнхийн Мөнхзул
3. Сиваев Александр Владимирович

Дээрх 3 тогтоолыг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан болохыг та бүхэнд мэдэгдлээ. Хувьцаа эзэмшигчдийн хуралдаа идэвхтэй оролцсон хувьцаа эзэмшигчдэдээ баярлалаа! Хуралтай холбоотой сайжруулах, анхаарах зүйлс байвал хувьцаа эзэмшигчдийн хурлын комиссын дарга Х.Доржзовд, хурлын дарга Э.Алтанзул миний биед хандах, компанийн вэбсайтаар дамжуулан саналаа илгээх, мэдээлэл авахад нээлттэй. Хувьцаа эзэмшигч та

бүхэн компанидаа итгэх итгэлээ хадгалж, хувьцаа эзэмшигчдийн хуралдаа идэвхтэй оролцож байгаад талархснаа илэрхийлье.
Өнөөдрийн хурал хаасныг мэдэгдье.


Хурал 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 12:55 минутад өндөрлөв.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:



Х.Доржзовд

ТАНИЛЦСАН ХУРЛЫН ДАРГА:



Э.АЛТАНЗУЛ